

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, ОЛОН УЛС СУДЛАЛААР ЭРДМИЙН ЗЭРЭГ ХАМГААЛУУЛАХ ЗӨВЛӨЛ АНХНЫ ЭРДЭМТЭНЭЭ ТӨРҮҮЛЭВ

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ч.Батцэцэг “Монгол Улс, БНХАУ-ын харилцаанд Өвөр Монголын Өөртөө Засах Орны эзлэх байр суурь (XX зууны дунд үеэс XXI зууны эхэн үе)” сэдвээр нэгэн сэдэвт зохиол бичиж, 2004 оны 5-р сарын 25-нд МУИС-ийн Олон Улсын Харилцааны Сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгааллаа.

Монгол Улсын гадаад харилцааны түүхийн судлалд Хятад судлал, түүний дотор язгуур угсаа нэгт монгол үндэстний асуудал, Өвөр Монгол онцгой байр эзэлдэг. Гэвч Монгол, Хятадын харилцаанд Өвөр Монголын эзлэх байр суурийг тодорхойлж, монгол үндэстэн хоорондын дотоод харилцааны түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан, бодит үнэнийг олон нийтийн хүртээл болгох ажил эрдэмтэн судлаачдын өмнө тулгамдсан асуудлын нэг болж байв. Чухам ийм нөхцөлд хятад судлаач Ч.Батцэцэг “Монгол Улс, БНХАУ-ын харилцаанд Өвөр Монголын Өөртөө Засах Орны эзлэх байр суурь”-ийг XX зууны дунд үеэс эдүгээ хүртэл түүхэн зүйн үүднээс улируулан судлаж, цогц болгон нэгэн сэдэвт зохиол бичсэн нь цаг үеийн шаардлагад нийцэж чухал ач холбогдолтой боллоо.

Ч.Батцэцэг нэгэн сэдэвт зохиолдоо Монгол, Хятадын харилцаа, түүнд өвөр монголчуудын нөлөө, хүчин зүйл, гүйцэтгэж байгаа үүргийг бодитоор тусгаж, он цагийн агуулгаар үечлэн, үе тус бүрийн онцлогийг тухайн нийгмийн байдал, олон улсын харилцааны чиг хандлагатай холбон гаргажээ. Монгол Улс, БНХАУ-ын харилцаанд ӨМӨЗО-ы эзлэж байгаа байр суурийн түүхэн хөгжлийн явц, эерэг сөрөг тал, ирээдүйн төлөвийг үндэсний аюулгүй байдлын хүрээнд авч үзэн, түүхэн сургамжийг орчин үеийн асуудалтай холбон дүгнэсэн байна.

Судлаач Ч.Батцэцэг нь хоёр орны харилцаа, түүнд ӨМӨЗО-ы эзлэх байр суурийг геополитикийн үүднээс судлах оролдлого хийж, “Монгол Улс нь хоёр гүрний зүгээс геостратегийн туйлын чухал байршилтайд тооцогддог учир геостратегийн орон зайд Монгол Улсын эзлэх байр суурийг тодорхойлохоос гадна манай улс өөрийн геополитикийн бодлогыг боловсруулах асуудал маш чухал. Хил залгаа хоёр гүрний улс төрийн байдал, хөгжил дэвшил манай улсын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлнө. Өнөөдөр манай улс цөмийн зэвсэгтэй хоёр их гүрэн, хоёр том эдийн засаг –зах зээл, хоёр өөр соёл иргэншил, гэхдээ хоёр талаасаа хил дамнасан нэг монгол угсаатан буюу их үндэстнүүдийн доторхи цөөн үндэстнээр хүрээлэгддэг өвөрмөц онцлог байдалд оршин тогтнож байна. Даяаршлалын өнөөгийн нөхцөлд бие даасан тусгаар нэгэн үндэстний хувьд хүн ам, удмын сангаа хадгалах, нүүдлийн соёл иргэншил, түүх, хэл бичиг, ёс заншил өв уламжлалаа авч үлдэхийн тулд хил залгаа монгол угсаатны дунд соёлын хүрээгээ тэлж, хил хязгаараа бэхжүүлэх зорилт бидний өмнө тулгарч байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Эрдмийн зэрэг хүртсэн судлаачынхаа цаашдын
судалгааны ажилд амжилт хүсье.